

МӨНГӨ ЗЭЭЛИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮДИЙН СҮҮЛИЙН ҮЕИЙН ХАНДЛАГА

Мөнгөний бодлого, судалгааны газрын захирал Б. Энххуяг

2000 оноос эхлэн банк санхүүгийн салбарын ажиллагаа тогтворжиж тус салбарын тоон үзүүлэлтүүд өндөр хурдтай өссөн. Тэсрэлтийн гэж тодорхойлж болох хурдцаар эдийн засаг дахь мөнгө, зээл, хадгаламжийн хэмжээ 2000 оноос хойш өссөнг хүснэгт харуулна.

Хүснэгт. Банкны салбарын гол үзүүлэлтүүдийн өсөлт, 2000-2004 онуудын 6 дугаар сарын эцсийн байдлаар

Үзүүлэлт	2000/06	2001/06	2002/06	2003/06	2004/06
1. Нийт мөнгө M2 (тэрбум ₮)	251.8	313.9	401.0	557.7	812.2
Нийт мөнгөний жилийн өсөлт, %		24.7	27.7	39.1	45.6
2. Зээл (тэрбум ₮)	58.0	97.5	191.0	327.9	526.7
Зээлийн жилийн өсөлт, %		68.1	95.9	71.7	60.6
3. Харилцах (тэрбум ₮)	24.8	29.5	55.9	67.9	84.5
Харилцахын жилийн өсөлт, %		19.0	89.5	21.5	24.4
4. Хадгаламж (тэрбум ₮)	111.6	158.8	213.3	348.7	557.4
Хадгаламжийн жилийн өсөлт, %		42.3	34.3	63.5	59.9
5. Чанаргүй зээл (тэрбум ₮)	18.1	12.1	16.0	33.3	44.3
Чанаргүй зээлийн жилийн өсөлт, %		-33.1	32.2	108.1	33.0
6. Чанаргүй зээл/ нийт зээлийн харьцаа	0.31	0.12	0.08	0.10	0.08
7. Төгрөгийн зээлийн дундаж хүүний түвшин жилийн хувиар	38.9	34.5	33.4	32.4	30.3

Дээрхи гүнзгийрч буй санхүүгийн зуучлал, түүний мөнгөний бодлого, инфляцид үзүүлэх үр нөлөөг дараахь хэдэн шалтгаанаар 2000 оноос хойш Монголбанк тайлбарлаж ирсэн. Үүнд:

- 1990 онуудын банкны дараалсан хямралыг гэтлэн давж банкны бүтцийн өөрчлөлтийн хатуу ч, шаардлагатай арга хэмжээнүүдийг Монголбанк авч хэрэгжүүлснээр банкны салбарын ажиллагаа эрүүлжиж тогтворжсон,

- Эдийн засаг дахь мөнгө асар хурдацтай өссөн нь үгүйлэгдэж байсан санхүүгийн зуучлал хэвийн явагдах болж иргэд банкин дахь хадгаламжаа нэмэгдүүлснээр банкуудын зээл олгох эх үүсвэр түргэн өссөн,
- Зээл, түүний барьцаа тойрсон хууль эрх зүйн орчин чангарсан,
- Төрийн мэдлийн банк нэгээс бусад нь хувьчлагдаж банкууд эзэнтэй болсон,
- Мөнгөний өсөлт инфляцийн өсөлт болоогүй нь Монголын эдийн засаг дахь мөнгөний эрэлтийн функци өөрчлөгдсөн, санхүүгийн зуучлалын гажуудал арилсантай холбоотой,
- Гадаадаас Монголын банкны салбарт дорвитой хөрөнгө оруулалт сүүлийн жилүүдэд хийгдсэн,
- Зээлийн хэмжээ нэмэгдсэн ч түүний өртөг болох зээлийн хүүний түвшин дорвитой буураагүй,
- Санхүүгийн зуучлалын дараагийн сонгодог суваг болох хөрөнгийн захын ажил үйлс унтаа хэвээр нөхцөлд банкуудын дангаар ноёрхол үргэлжилсээр...

Гэтэл сүүлийн үед зарим банкууд хэт тоон үзүүлэлтүүдийн өсөлтийн араас хөөцөлдөх хандлага ажиглагдах болов. Жишээ нь, Манай банкны нийт актив 200 тэрбум төгрөгт хүрлээ гэх ч юмуу, эсхүл жилийн эцсийн хаалтын гүйлгээгээр активын дүнгээ хий өсгөн том банк болж харагдах гэсэн явдлууд гарсан. Гол нь банкны хувьд актив, эсхүл зээлийн тоо хэмжээ чухал биш, түүний чанар буюу эргэн төлөгдөх магадлал чухал байдаг, арилжааны банкууд тоон үзүүлэлтийн өсөлтөөр хөөцөлдөх ёсгүй.

Үүний хажуугаар банкуудын дундах өрсөлдөөнөөс үүдэн зээл олголтын шаардлагаа бууруулан илүү эрсдэлтэй зээлдэгчидтэй харьцаж эхлэх, урьд өмнө нь олгож байгаагүй зээлийн бүтээгдхүүн нэвтрүүлснээр шинэ төрлийн эрсдэлтэй учрах болсон зэргээс шалтгаалан нийт чанаргүй зээлийн хэмжээ эрс өссөнг дээрхи хүснэгтээс харж болно.

Төрөөс банкуудыг зээлийн хүүний эрсдлийн сангийн татвар болон хадгаламжийн хүүний татвар зэргээс чөлөөлж үйл ажиллагааг нь бодитой дэмжиж ирсэн.

Банкуудын дүрмийн сангийн доод хэмжээ 4 тэрбум ₮-с 8 тэрбум ₮ болж өсөхийн хирээр ялангуяа жижиг банкуудын хувьд шинэ эх үүсвэрийг зээл болгон байршуулах шахалт эрс нэмэгдэх нь жижиг банкуудын оршин тогтнох орон зай цаашид байх эсэхэд нөлөөлнө. Монголбанкнаас саяхан хийсэн судалгаагаар банкны өрсөлдөөнөөс шалтгаалан Активт ноогдох ашиг болон Өөрийн хөрөнгөд ноогдох ашиг гэсэн гол хоёр үзүүлэлтийн түвшин манай арилжааны банкуудын хувьд эрс буурсан байгаа нь хязгаарлагдмал зах зээл дээр бараг ижил төрлийн бүтээгдхүүнээр өрсөлддөг Монголын арилжааны банкуудын хувьд маш том сорилт болох нь гарцаагүй юм.

Монголбанкнаас сүүлийн нэг жилд хийсэн шалгалтаар Монголбанкны хянан шалгагч нарын зээлийн ангилалын явцад тухайн банкны ангилсан зээлээс нэлээд нь чанаргүй зээл болж ангилагдах болсон нь Монголбанкны анхаарлыг татаж байна.

2001 оны 9 дүгээр сарын 11-ны өдрийн гэмт халдлагаас хойш мөнгө угаалт болон терроризмтой тэмцэх асуудал дэлхийн нийтийн анхаарлын төвд орших болсон. Энэ чиглэлээр Монгол улсын холбогдох хууль тогтоомж батлагдан гарах бөгөөд санхүүгийн хөрөнгө мөнгөний урсгалд хяналт тавих нэгж байгуулагдах асуудал удахгүй яригдах болно.